



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/302

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 02 дугаартай хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянцогт, Баянчандмань, Баянжаргалан сумдад гарсан мал гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтоосон үед өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад шаардагдах үйл ажиллагааны зардал, Жаргалант сумын Соёлын төвийн дээврийн хэсэг хүчтэй салхины улмаас хууларсан тул засварлахад шаардагдах нийт 9,931,000 (есөн сая есөн зуун гучин нэгэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-г зөвшөөрсүгэй.

2.Олгосон санхүүжилтийг зохих журмын дагуу зарцуулж, тайлагнахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



4123018780

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дүгээр сарын 01 -ны өдрийн  
А/302 дугаар захирамжийн хавсралт



СУМДАД ОЛГОХ ЗАРДАЛ

№	Сумдын нэр	Хэмжээ /төгрөг	Зориулалт
1	Баянцогт	1,500,000	Шатахуун
2	Баянчандмань	1,500,000	Шатахуун
3	Баянжаргалан	1,500,000	Шатахуун
4	Жаргалант	5,431,000	Дээврийн засвар
5	Нийт	9,931,000	

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/305

Зуунмод

Дуудлагын худалдааг зарлан  
мэдээлэх, бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хуралдааны 08, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 58 дугаар тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн хавсралт дахь тээврийн хэрэгсэл, Баянчандмань сумын Засварын хуучин цехийн барилгын дуудлагын худалдааны зарыг олон нийтэд нээлттэй зарлан мэдээлж бүртгэх ажлыг зохион байгуулсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдааны зарыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор баталсан аймгийн өмчийн харилцааг зохицуулах журмын 5.3.5, 5.3.6, 5.3.8.6-д заасны дагуу зарлан мэдээлэх, бүртгэхийг Баянчандмань сумын Засаг дарга (Г.Ариунболд)-д даалгасугай.

3.Дуудлагын худалдааны зарыг хавсралтаар баталсугай.

4.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавихыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 02-ны өдрийн  
А/305 дугаар захирамжийн хавсралт



Нээлттэй дуудлагын худалдааны зар

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 14 дүгээр хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 08, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн 58 дугаар тогтоолын дагуу дараах эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдана.

№	Хөрөнгий нэр	Үйлдвэрлэсэн он	Улсын дугаар	Худалдах үнэ	Дэнчингийн хэмжээ	Бүртгэлтэй байгууллага
1	Lucong-920 /ковш/	Бичиг баримтгүй		3,000,000	900,000	Баянчандмань сумын ЗДТГ
2	УАЗ-469	2010	92-05 ТӨА	2,000,000	600,000	Баянчандмань сумын ЭМТ
3	Засварын хуучин цехийн барилга	1969		7,000,000	2,100,000	Баянчандмань сумын ЗДТГ

Дуудлагын худалдааны дэнчинг Төрийн сан дах Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 10014015408 тоот дансанд тушааж баримт авсан байна. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 10 цаг 20 минут хүртэл Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын иргэний тэнхимд хүлээн авна. Дуудлагын худалдаа нь 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 10:30 цагт Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын иргэний тэнхимд явагдана.

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин, оролцох эрхийн төлбөр болох 30,000 төгрөг төлсөн баримт, иргэний үнэмлэхний хуулбар зэрэг баримтыг ирүүлнэ.

Дээрх эд хөрөнгийг тухайн эд хариуцагч сум, байгууллага дээр очиж үзэж болох бөгөөд мэдээллийг 99268011, 99162649 утсаар холбогдон авна уу.

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/307

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Өсвөрийн аварга шалгаруулах "Шараваа 2023" Сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Алтанхуяг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Гишүүд:

А.Хажидмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёл, спортын бодлого, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ц.Дөлгөөн (Аймгийн Засаг даргын орлогчийн туслах)

Ц.Нарантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

М.Буянхишиг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Д.Намсрайноров (Монгол туургатан театрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Л.Эрдэнэцэцэг (Хүмүүн цогцолбор сургуулийн ерөнхий захирал)

Ц.Лхагва-Орлом (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Оюунбилэг (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

2.Арга хэмжээний бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010800

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/309

Зуунмод

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1.дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Засгийн газар, Соёлын яамнаас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын тухай хууль, Засгийн газрын “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолыг үндэслэн орон нутагт соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах сумдын соёлын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, иргэд, хөдөлмөрчдөд соёл, урлагийн үйлчилгээ үзүүлж соён гэгээрүүлэх зорилго бүхий “Соёлын сэргэлт-2023” аяныг зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

М.Отгонбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Д.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

А.Хажидмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёл, спортын бодлого, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ц.Нарантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Д.Алтанхуяг (Биеийн тамир, спортын газрын дарга)

М.Буянхишиг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Д.Намсрайноров (Монгол туургатан театрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Зоригтбаатар (Нийтийн номын сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Сүхбаатар (Музейн захирал)

Т.Идэр (Албан бус насан туршийн боловсрол төвийн захирал)

Ц.Ууганбаатар (Төв аймаг дахь Төрийн Цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

4123010796

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa

Ж.Энхбаатар ("Төв" телевизийн захирал)  
Ч.Сарангэрэл (Зуунмод сумын Засаг дарга)  
Ш.Батмөнх (Зуунмод сумын Соёлын төвийн дарга)

Нарийн бичгийн дарга:  
Б.Тунгалаг (Соёл, урлагийн газрын дарга)

2."Соёлын сэргэлт-2023" аяны нээлтийг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө шаардагдах төсвийг батлуулж, бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/310

Зуунмод

“Түүхт ой угтсан бүтээлч ажил”-ын  
аян зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “Түүхт ой угтсан бүтээлч ажил”-ын аяныг 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зарлан хэрэгжүүлсүгэй.


2. “Түүхт ой угтсан бүтээлч ажил”-ын аяныг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Аян зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн тохижилт, бүтээн байгуулалт, цэвэрлэгээний ажлыг өрнүүлж, үр дүнд хүргэж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүд тохижилт, бүтээн байгуулалт, цэвэрлэгээний ажлыг өрнүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат), агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Аяныг удирдан зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнд нь хяналт тавьж, нутгийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог ханган, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах зэргээр үр дүнтэй ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.МӨНХБААТАР

4123010840

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 03 -ны өдрийн  
А/310 дугаар захирамжийн хэвсрэлт



**“ТҮҮХТ ОЙ УГТСАН БҮТЭЭЛЧ АЖИЛ”-ЫН  
АЯНЫ УДИРДАМЖ**

**Нэг.Зорилго:**

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойгоо угтан нийтийн эзэмшлийн болон байгууллага, аж ахуйн нэгжийн эзэмшлийн барилга байгууламж, явган зам, хашаа хайс, авто зогсоолыг шинэчлэн тохижуулж, өнгө үзэмжийг сэргээн, засварлах, мод, бут сөөг тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг бүтээн байгуулалтын ажлууд өрнүүлж, бүх нийтээрээ орчны хог хаягдлыг цэвэрлэж ая тухтай орчин бүрдүүлэхэд энэхүү аяны зорилго оршино.

**Хоёр. Аяны хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа**

Аянд сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хамрагдана.

Аяныг 2023 оны 05 дугаар сарын 10-наас 07 дугаар сарын 10-ны өдөр буюу 2 сарын хугацаатай зохион байгуулна.

**Гурав. Аяны чиглэл:**

1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайг тохижуулах;
2. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх;
3. Нийтийн эзэмшлийн талбайд мод бут сөөг тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;
4. Байгууллага, аж ахуйн нэгжийн эзэмшлийн барилга байгууламжийн гадна фасад, дээврийн өнгө үзэмжийг сайжруулан, будаж сэргээх;
5. Байгууллага, аж ахуйн нэгжийн гадна фасадны гэрэлтүүлэг болон орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх;
6. Байгууллага, аж ахуйн нэгжийн хашаа хайсыг сэргээн засварлаж, гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх;
7. Орчны бохирдлыг багасгах, хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах;
8. Иргэд, олон нийт, хүүхэд залууст гудамж талбайд ил задгай хог хаяхгүй байх соёлыг түгээх, хог хаягдал байгаль орчинд хэр хор хөнөөлтэй талаар зөв мэдлэг, мэдээллийг өгөх уриалга болон уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах;

**Дөрөв. Аяны зохион байгуулалт:**

Аяныг аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд сум багт сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгүүд ажиллана.

Тав. Аяны үр дүнг тайлагнах:

Аяны хүрээнд хийгдэж буй ажлын явцыг иргэд олон нийтэд радио, телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, сурталчлан танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулна.

Аяны хэрэгжилт, үр дүнг сумд 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймгийн ажлын хэсэгт, аймгийн ажлын хэсэг 2023 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнана.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН САЛБАР ХОРОО



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/312

Зуунмод

Электрон тамхи түүний дагалдах  
хэрэгслийг худалдан борлуулахыг  
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Тамхины хяналтын суурь конвенцын 1 дүгээр зүйлийн (е), 4 дүгээр зүйлийн 4, 5 дугаар зүйлийн 2.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, өсвөр үе, залуучуудыг тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт электрон тамхи буюу вейп түүний дагалдах хэрэгслийг 21 насанд хүрээгүй хүнд, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор худалдахыг, бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл, олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар, нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчинд хэрэглэхийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаагаар хориглосугай.

2.Аймгийн хэмжээнд нийтийн болон хувийн эзэмшлийн барилга байгууламж, объектын хана, зам талбайд байршуулсан электрон тамхи буюу вейпийн хэрэглээг сурталчилсан далд агуулга бүхий сурталчилгааны самбар байршуулахгүй байх, байршуулсан тохиолдолд сурталчилгааг буулгах мөн цахим орчноор хууль бус зар сурталчилгааг түгээхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг), сумдын Засаг дарга нарт, электрон тамхи буюу вейпийн хор хөнөөлийн талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөвлөгөө мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газар(С.Мөнхтуяа), Боловсрол шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа) нарт тус тус даалгасугай.

3.Холбогдох хууль тогтоомж болон захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг), Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

1123010888  
My.Doc.zaliramj.2023-2.tif



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/315

Зуунмод

Газрын цахим болон танхимын  
дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", Зуунмод сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Номт 1-р багт Амины орон сууц зориулалттай 300м<sup>2</sup>-аар 3н нэгж талбар, 539м<sup>2</sup> газар, 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц зориулалттай 239м<sup>2</sup> газар, Зочид буудлын цогцолбор зориулалттай 7684м<sup>2</sup> газрыг эзэмших эрхийг олгох цахим болон танхимаар дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Батбаяр

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Бадамгарав

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Д.Амартүвшин

(Зуунмод сумын Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

С.Намшир

(Зуунмод сумын Нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга:

Г.Баярсайхан

(Зуунмод сумын Газрын даамал)

2. Дуудлага худалдааг Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу зохион байгуулахыг Дуудлага худалдааны ажлын хэсгийн дарга (Б.Батбаяр)-д хариуцуулсугай.

3. Дуудлага худалдаанд ялсан ялагчтай гэрээ байгуулж, дуудлага худалдаанаас орсон орлогын үнийг төсөвт бүрэн оруулахыг Зуунмод сумын газрын даамал (Г.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Насанжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

. 4123010821

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/319

Зуунмод

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн  
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын  
салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4, 42 дугаар зүйлийн 42.1.1, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/807, А/216 дугаар хамтарсан тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон чадварыг илрүүлэх, тодорхойлох, тухайн хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрт тусгах арга хэмжээний ерөнхий чиглэлийг боловсруулах, хүүхдэд тохирох боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг тодорхойлж чиглүүлэх, холбон зуучлах, шаардагдах үйлчилгээнд хамруулах, үр дүнд хяналт тавих үүрэг бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар комиссын дарга:

Д.Мөнхцэцэг (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Н.Отгончимэг (Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн зөвлөх эмч)

С.Дүүриймаа (Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн тасгийн их эмч)

Б.Анударь (Боловсрол, шинжлэх ухааны газрын хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичиг, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн)

П.Дэлгэрсүрэн (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрх хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д.Бадамцэцэг (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

М.Амаржаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

· 4123010814

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нь нэмэгдүүлж тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, салбар комиссын ажиллах дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг салбар комисс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/85 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/322

Зуунмод

Төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Пёнтек хотод 2023 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд “Монголын соёлын өдөрлөг” арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

- |                |   |
|----------------|---|
| Б.Уранжаргал   | (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч)                                       |
| Б.Одончимэг    | (Аймгийн төсвийн Ерөнхий нягтлан бодогч)  |
| Ж.Эрдэнэжаргал | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)  |
| Д.Бямбадулам   | (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн) |
| С.Ганчимэг     | (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга)                   |
| Д.Батсуурь     | (Алтанбулаг сумын Засаг дарга)  |
| Т.Түвшинбат    | (Бүрэн сумын Засаг дарга)   |
| Г.Ариунболд    | (Баянчандмань сумын Засаг дарга)  |
| М.Мөнх-Эрдэнэ  | (Баян сумын Засаг дарга)  |
| З.Дэлгэрцэцэг  | (Баяндэлгэр сумын Засаг дарга)  |

2.Төлөөлөгч Б.Уранжаргал, Б.Одончимэг, Ж.Эрдэнэжаргал, Д.Бямбадулам, С.Ганчимэг, Д.Батсуурь, Т.Түвшинбат, Г.Ариунболд, М.Мөнх-Эрдэнэ, З.Дэлгэрцэцэг нар Бүгд Найрамдах Солонгос Улсын Пёнтек хотод 2023 оны 06 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд тус хотын захирагчийн урилгаар “Монголын соёлын өдөрлөг” арга хэмжээнд оролцох болсонтой холбогдуулан цахим албан гадаад паспорт олгуулахаар Гадаад харилцааны яамны Консулын газарт хүссүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



- 4123010829

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/323

Зуунмод

Ажиллагааны удирдлагын бүрэлдэхүүнийг  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны ЗГ-2/186 дугаар албан бичиг, Шадар сайдын 2023 оны 06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Стратегийн команд штабын сургуульд оролцох ажиллагааны удирдлагын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллагааны удирдлагын бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга (Г.Эрдэнэбат), сургуульд оролцох албан тушаалтнуудын үндсэн ажил, үүргийн цагт зохицуулалт хийж бүрэн хамруулахыг холбогдох байгууллагуудын төсвийн захирагч нарт даалгасугай.

3. Стратегийн команд штабын сургуулийн нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат), Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д. МӨНХБААТАР



. 4123010831

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



Аймгийн Засаг даргын 2023 оны  
 05 дугаар сарын 09 ны өдрийн  
 А/323 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН


№	Нэгжийн нэр	Албан тушаал	Овог, нэр
1.	Ерөнхий удирдагч	Аймгийн Засаг дарга	Д.Мөнхбаатар
Нэг. Ослын үеийн шуурхай штабын удирдлага			
2.	Ослын үеийн удирдагч	Аймгийн Засаг даргын орлогч	Г.Сурмаа
3.	Ослын үеийн удирдагчийн орлогч дарга	Онцгой байдлын газрын дарга	х/а Н.Төмөрбаатар
Хоёр. Холбогч офицер			
4.	Холбогч офицер	Цэргийн штабын дарга	д/х Т.Төмөрчөдөр
5.		Онцгой байдлын газрын Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн	а/д П.Өлзийбаяр
Гурав. Олон нийтийн мэдээллийн ажилтан			
6.	Олон нийтийн мэдээллийн ажилтан	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн дарга	С.Цогбаяр
7.		Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтан	Д.Бадамсүрэн
8.		Онцгой байдлын газрын Ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн	а/д Л.Бастөгс
Дөрөв. Аюулгүй байдлын ажилтан			
9.	Аюулгүй байдлын ажилтан	Тагнуулын хэлтсийн ажилтан	а/х Б.Эрдэнэ-Очир
10.		Онцгой байдлын газрын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн	д/ч Б.Цэнд-Очир
11.		Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга	д/х Н.Доржбалжид
Тав. Ажиллагааны баг			
12.	Ажиллагааны багийн ахлагч	Онцгой байдлын газрын орлогч дарга, урьдчилан сэргийлэх тасгийн дарга	д/х Г.Эрдэнэбат
5.1 Довтолгооны баг			
13.	Эрэн хайх, аврах ажиллагаа, гал түймэр унтраах хэсэг	Зуунмод сум дахь Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн захирагч	а/х Бадамсамбуу
14.	Эрэн хайх, аврах ажиллагаа, гал түймэр унтраах хэсэг	Зуунмод сум дахь Эрэн хайх, аврах салбарын захирагч	д/ч Б.Баттөмөр
15.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэсэг	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга	Н.Энхтайван
16.	Хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах хэсэг	Төв аймаг дахь Цагдаагийн газрын дарга	Ч.Алтанхуяг
17.	Хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах хэсэг	Төв аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга	Д.Магвасүрэн
5.2 Ажлын хэсэг			
18.	Дэд бүтэц хариуцсан хэсэг	УБЦТС ТӨХК-ийн ашиглалт засварын Зуунмод төвийн дарга	Л.Гансүх

19.		УБЦТС ТӨХК-ийн Зуунмод хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга	А.Өнөржаргал
20.		"ТӨВ АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Д.Болдбаатар
21.		Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГазрын дарга	Ц.Батсүх
22.		Байгаль орчин, аялал жуучлалын газрын дарга	Ж.Даш-Яйчил
5.3 Бие даасан нөөц			
23.		Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч	х/а Ж.Мөнхбаяр
24.	Дэмжлэг үзүүлэх хэсэг	Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга	х/а С.Өлзийбат
25.		Төв аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга	х/а М.Жамбалсүрэн
26.		Монгол туургатан театрын захирал	Д.Намсрайноров
27.			
28.	Зуунмод сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг	Зуунмод сумын Засаг дарга	Ч.Сарангэрэл
29.		Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дарга	Г.Батжаргал
30.		Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч	д/ч Д.Тэгшбаяр
31.	Сумдын ерөнхий зориулалттай мэргэжлийн анги	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын дарга нар	
Зургаа. Төлөвлөлтийн баг			
32.	Төлөвлөлтийн багийн ахлагч	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Саран-Эрдэнэ
33.		Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	С.Магнайбаяр
34.		Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга	Б.Насанжаргал
35.	Хариу арга хэмжээний төлөвлөлтийн хэсэг	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн	х/ч Л.Нямдаваа
36.		Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга	М.Буянхишиг
37.		Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн дарга	С.Орхон
38.		Соёлын газрын дарга	Б.Тунгалаг
39.	Нөхцөл байдлын үнэлэх, мэдээлэл цуглуулах хэсэг	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга	Э.Гэрэлцогт
40.		Мал эмнэлгийн газрын дарга	Б.Болдбаатар
41.		Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	Н.Энхбат
42.		Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч	а/х Б.Батзаяа
43.	Хүн хүч, техник хэрэгслийн тооцоо, судалгааны хэсэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	Ц.Нарантуяа
44.		Статистикийн хэлтсийн дарга	Ж.Отгончулуун
45.		Татварын хэлтсийн дарга	Д.Мөнх-Учрал
Долоо. Нөөц хангалтын хэсэг			
46.	Нөөц хангалтын хэсгийн дарга	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Д.Мөнхцэцэг

47.		Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	Н.Гантулга
48.	Хүнсний хангамжийн үйлчилгээний хэсэг	Улсын нөөцийн 07 дугаар ангийн захирагч	Б.Ганбат
49.		Улаан загалмайн хорооны дарга	Б.Отгончимэг
50.	Эмнэлгийн нэгж	Эрүүл мэндийн газрын дарга	С.Мөнхтуяа
51.	Харилцаа холбоо, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэсэг	МХСүлжээ ТӨХК-ийн Төв аймаг дахь холбооны газар	М.Жамъяаншарав
52.		Монголын цахилгаан холбоо ТӨХК-ийн Төв аймаг дахь газар	Б.Энхцогт
53.		Онцгой байдлын газрын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	а/д Д.Мөнхбаатар
54.		Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга	Д.Батцэцэг
55.	Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүн, хүчний хангалтын хэсэг	Авто тээврийн төвийн дарга	Н.Аасүрэн
56.		Орон нутгийн өмчийн газрын дарга	Д.Батжаргал
57.	Ажиллагааны зургийн хэсэг	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч	а/х Б.Цэрэнхүү
58.		Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	а/а Б.Бадмаараг
59.		Гал түймэр унтраах 24 дүгээр ангийн салааны захирагч	д/ч Н.Мөнх-Оргил
60.		Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл	х/ч Б.Ариунболд
61.		Төвийн аймгийн барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	Д.Алтансүх
Найм. Санхүү, захиргааны хэсэг			
62.	Санхүү, захиргааны хэсгийн ахлагч	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	М.Отгонбат
63.	Худалдан авалтын хэсэг	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Ю.Бямбацогт
64.		Аймгийн ЗДТГ-ын төсвийн ерөнхий ня-бо	Б.Одончимэг
65.	Зардал хариуцсан хэсэг	Онцгой байдлын газрын Ахлах нягтлан бодогч	х/ч Г.Мөнхсоёл
66.		Хүнс хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч	Б.Бямбасүрэн
67.		Эрүүл мэндийн газрын ахлах нягтлан бодогч	Б.Төмөрчөдөр
68.		Хөдөлмөр халамжийн үйлилгээний газрын ахлах нягтлан бодогч	Н.Ууганбаатар
69.	Захирамж, баримт хэсэг	АЗДТГазрын хууль эрх зүйн хэлтсийн дарга	Б.Ганхуяг
70.		АЗДТГазрын хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн	С.Сэдэд
71.		АЗДТГ-ын бичиг хэрэг архивийн эрхлэгч	П.Батчимэг
72.	Баримт бичиг хэвлэх, олшруулах, түгээх нэгж	АЗДТГазрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга	Т.Хуягбаатар
73.		Онцгой байдлын газрын Бичиг хэрэг, архивийн эрхлэгч	а/а Б.Уянга
74.	Цагийн бүртгэл	Үйлчилгээний албаны дарга	Э.Баярбат

— оОо —

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 09 -ны өдрийн  
А/323 дугаар захирамжийн 1 дугаар хавсралт



АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

*Штабын даргын үүрэг:*

- Штабын үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Ослын үеийн аюулгүй байдлыг хангах;
- Ослын үеийн удирдлагын байрыг байгуулах;
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- Нэн тэргүүний шаардлагатай арга хэмжээг эхлүүлэх;
- Ослын үеийн дагаж мөрдөх зорилго, стратегийг тодорхойлох;
- Шаардлагатай үед төлөвлөлтийн хурлыг удирдах;
- Ослын үеийн ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;
- Удирдлагын штаб, Ажиллагааны удирдлагын үйл ажиллагааг зохицуулах;
- Нэмэлт хүч хэрэгсэл эсвэл хүч хэрэгслийг буулгах хүсэлтийг батлах;
- Хэвлэл, мэдээллийнхэнд өгөх мэдээллийг хянах;
- Ажиллагаанд оруулах шийдвэрийг гаргах;
- Ослын дараах арга хэмжээний тайлангийн боловсруулалтыг хангах;
- Хэвлэл, мэдээллийнхэнд мэдээлэл өгөх.

*Зохицуулагчийн үүрэг:*

- Зохицуулагч нь үйл явдлын төрлөөс хамаарч баг, бүрэлдэхүүнийг томилох;
- Төлөвлөлт, санхүү, хариу арга хэмжээний гаргасан төлөвлөгөө, шаардлагатай төсвийн тооцоог аймаг, орон нутгийн удирдлага, онцгой комисст танилцуулж, бэлэн байдлыг хангах нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Багийн ахлагч нарыг үүрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, хяналт тавих;
- Менежерийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх;
- Байгууллага, нэгжийг идэвхжүүлэх, идэвхжлийн зэргийг өөрчлөх, цуцлах шийдвэр гаргах саналыг аймгийн Онцгой комиссын даргад хүргүүлэх;
- Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах - Салбар хоорондын багуудыг удирдан зохион байгуулах, ажлыг тайланг хэлэлцэх, шийдвэр гаргах;
- Эрсдэлийн мэдээлэл, харилцаа, хэвлэлийн тоймыг хянан баталгаажуулах.

*Менежерийн үүрэг:*

- Багийн үүрэг, хариуцлагыг тодорхойлж, гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;
- Багийг хүний нөөцөөр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөж, удирдан зохион байгуулах;
- Хүний нөөц, санхүүгийн болон техникийн дэмжлэг авах талаар зохицуулагчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;

- Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хурлын зар түгээх, хурлын тэмдэглэл хөтлөх Багуудаас тайланг 7 хоног бүр авч нэгтгэн зохиоцуулагчид танилцуулах.

*Мэдээллийн хэсэг:*

- Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацах үнэн зөв, хүртээмжтэй, цаг үеэс олсон мэдээллийг бэлтгэх;
- Удирдлагаас осолтой холбоотой гарах бүх мэдээллийг батлуулах;
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээг давтамжтайгаар хүргэх;
- Шаардлагатай үед мэдээ явуулах, ярилцлага, газар орон дээрх сурвалжлагыг зохион байгуулах;
- Осолтой холбоотой мэдээлэл, тойм, нэвтрүүлгийг хариуцах;
- Осолтой холбоотой мэдээллийг ослын хор уршгийг арилгах бие бүрэлдэхүүнд зориулж бэлтгэх.

*Аюулгүй байдлын хэсэг:*

- Аюултай нөхцөл байдлыг олж тогтоох, аюулыг бууруулах;
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулсан эсэхийг хянах;
- Ажиллагааны үеэр аюултай ажиллагааг зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх;
- Ослын үеийн ажиллагааны төлөвлөгөөнд аюулгүй байдлыг тусгасан эсэхийг шалгах;
- Ослын голомтод ослын нөхцөл байдлыг тогтоох эхний үнэлгээг эхлүүлэх;
- Эрүүл мэндийн төлөвлөгөөг хянах, батлах.

*Холбогч ажилтан:*

- Бусад байгууллагуудтай холбоо тогтоох, харилцан мэдээлэл солилцох ажилтан;
- Тусалж байгаа болон хамтран ажиллагч байгууллагуудын төлөөлөгчдийн нэр хаяг, утсыг тодотгох;
- Байгууллагуудын төлөөлөгчдийг хооронд нь холбоход дэмжлэг үзүүлэх, хяналт тавих;
- Байгууллага хооронд үүссэн болон үүсч болзошгүй асуудлыг олж тогтоох зорилгоор ослын ажиллагаанд хяналт тавих;
- Байгууллагуудын хүч хэрэгслийн хязгаарлалт, хүчин чадавхыг багтаасан одоо байгаа хүч хэрэгслийн талаарх мэдээллийг өгөх;
- Байгууллага тус бүрийн ажиллагаанд оролцох талаарх мэдээлэл, шаардлагыг хүргүүлэх.

*Холбогч ажилтны туслах:*

- Ослын үед Удирдлагын штабын бие бүрэлдэхүүний ажлын ачааллыг багасгах зорилгоор нэг буюу түүнээс олон туслах шаардлагатай болж болно. Удирдлагын штаб өөрсдийн туслахуудын ажиллагааг хамгийн үр дүнтэй байлгах асуудлыг хариуцна.

*Холбоо, зарлан мэдээллийн хэсэг:*

- Гамшгийн үеийн бүх төрлийн холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;

- Гамшгийн цагийн байдлын талаарх мэдээг хүлээн авах, мэдээлэх, удирдлагыг тасралтгүй мэдээлэл, холбоогоор хангах;
- Байгууллагын хэмжээнд холбоо зохион байгуулах, бусад байгууллагатай торын холбоо үүсгэх;
- Холбооны асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх.

*Ажиллагааны баг:*

- Төлөвлөлт, Санхүү, ар тал, хангалтын хэсгүүдийн үйл ажиллагааг тодорхойлж уялдаа холбоогоор хангах;
- Эрэн хайх, аврах хор уршгийг үр дүнтэй явуулах зорилго дээр үндэслэн тактикийг тодорхойлох, удирдлагын штабт танилцуулах;
- Хүн хүч хэрэгслийг хуваарилах санал гаргаж шийдвэрлүүлэх;
- Хэсэг, бүлгийн үйл ажиллагааг тодорхойлох;
- Тактикийн ажиллагааны аюулгүй байдлыг хангах;
- Тактикийн ажиллагааг удирдах;
- Шаардагдах нэмэлт хүч хэрэгслийг хүсэх/захиалах;
- Үйл ажиллагааны төлөвлөгөөний ажиллагаатай холбоотой хэсгийг боловсруулахад туслах;
- Гамшгийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой хэсгийн хэрэгжилтийг хянах;
- Тактикийн ажиллагааг дэмжих нэмэлт хүч хэрэгслийг хүсэх;
- Хүч хэрэгслийг даалгавраас татах;
- Удирдлагын штабтай холбоотой ажиллах, ажиллагаанд оролцогч бие бүрэлдэхүүнийг удирдлагаар хангах;
- Шаардлагатай алба, мэргэжлийн ангийг татан оролцуулах талаар удирдлагад санал гаргах, оролцуулах, удирдлагаар хангах, хяналт тавих;
- Ажиллагааны асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Бусад.

*Төлөвлөлтийн баг:*

- Гамшигтай холбоотой ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болон Улын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, Улсын Онцгой комисстой ажиллах төлөвлөлтийг төлөвлөгөөнд нэгтгэх;
- Гамшгийн үеийн ажлын төлөвлөгөөний бэлтгэлийг хангуулах;
- Ажиллагааны хэсгийн даргад гамшгийн үед ажиллах ажиллагааны төлөвлөгөө гаргахад шаардагдах мэдээллийг бэлтгэн өгөх;
- Төлөвлөлтийн хурлуудыг зохион байгуулах;
- Бүх төрлийн төлөвлөгөөнд тодотгол хийх, баталгаажуулах;
- Шинээр төлөвлөлтийг боловсруулах;
- Гамшгийн нөхцөл байдлын мэдээг нэгтгэх, удирдлагын штабт танилцуулах;
- Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах тусгай хүч хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох;
- Нөөц стратеги, гэнэтийн тохиолдлын төлөвлөгөө гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулах;
- Гамшгийн нөхцөл байдалд орсон онцгой өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх;
- Томилгоот бүрэлдэхүүний нөхөн хангалтыг хийх, хүний нөөцийн судалгаа хийх;

- Харилцаа холбоо, эмнэлэг, замын хөдөлгөөний талаар төлөвлөгөө бэлтгэх;
- Төлөвлөлтийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Бусад.

*Нөөц хангалт, дэмжлэг үзүүлэх баг:*

- Гамшгийн үед шаардлагатай нөөцийг тодорхойлох;
- Бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх;
- Олон улсын болон бусад байгууллагын өгсөн тусламжийн барааг хувиарлах, хүргүүлэх;
- Хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах;
- Нөөцөөс бараа материал шаардлагатай зүйлсийг гаргах;
- Шаардлагатай нөөцийг бусад хэсэгтэй хамтран шийдвэрлэх;
- Нөөцийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Удирдлагын штабын байрзүйн зургыг бэлтгэх, хөтлөх;
- Цаг агаарын болон бусад нөхцөл байдлын мэдээллээр хангах;
- Барилга байгууламжийн план зураг болон бусад төрлийн байр зүйн зургаар хангах ажлыг зохион байгуулах;
- Шаардлагатай тохиолдолд мэдээлэл цуглуулах тусгайлсан системийг бий болгох (жишээлбэл цаг агаарын талаар).

*Санхүү, захиргааны баг:*

- Шаардлагатай санхүү, зардлын дүгнэлт шинжилгээ бүхий мэдээллээр хангах;
- Хариуцсан байгууллагуудын мэдээллээс холбогдох мэдээллийг авах;
- Санхүүгийн хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх, шаардлагатай хэрэгслээр хангах;
- Бүх хэсэгт шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх;
- Санхүүгийн асуудлаар бүх төрлийн мэдээлэл өгөх;
- Бусад.

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/324

Зуунмод

Өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн дунд болон богино хугацааны баримт бичиг, 2023 оны нэгдсэн төлөвлөгөөнд Хууль зүйн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор Нутгийн удирдлагын байгууллага Хууль зүйн салбарын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Заамар сумын Хайлааст 3 дугаар багт зохион байгуулсугай.

2.Нутгийн удирдлагын байгууллага, Хууль зүйн салбарын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийн удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тус арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд 2,286,692 (хоёр сая хоёр зуун наян зургаан мянга зургаан зуун ерэн хоёр) төгрөгийг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т зөвшөөрсүгэй.

4.Өдөрлөгийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

5.Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010834





ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/327

Зуунмод

Аймгийн Түр хамгаалах байр,  
Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийн  
үйл ажиллагааг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.5, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.5, 19.1.6, 19.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Түр хамгаалах байр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд шаардлагатай төсвийг хавсралтаар баталсугай.

2.Түр хамгаалах байр, Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон сэтгэлзүйн зөвлөгөө тусламж шаардлагатай иргэн, хүүхдэд үйлчилгээ үзүүлж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Ч.Алтанхуяг), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (М.Буянхишиг) нарт үүрэг болгосугай.

3.Түр хамгаалах байр, Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 14,219,948 (арван дөрвөн сая хоёр зуун арван есөн мянга есөн зуун дөчин найм) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010842  
My.Doc.zahiranj 2023-2 ulirdi

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын 15 ны өдрийн А/1322 дүгээр  
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ТҮР ХАМГААЛАХ БАЙР, СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ  
ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХЭД ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хугацаа /2023/								Тоо ширхэг	Нийт үнэ
		5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар		
1	Зөөврийн компьютер /Dell Inspiron 3525 AMD Ryzen 7 5825U 8GB 512GB SSD 120Hz Notebook/	2,999,900	*	*	*	*	*	*	*	1 ш	2,999,900
2	Өнгөт принтер /Epson EcoTank L3256 Printer C11CJ67519/	855,900	*	*	*	*	*	*	*	1 ш	855,900
3	Бичгийн ширээ	554,900	*	*	*	*	*	*	*	1 ш	554,900
4	Сандал	219,900	*	*	*	*	*	*	*	1 ш	219,900
5	Сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээний хөлс	1,199,156	1,199,156	1,199,156	1,199,156	1,199,156	1,199,156	1,199,156	1,199,156	8 сар	9,593,248
<b>Нийт</b>											<b>14,219,948</b>



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/329

Зуунмод

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн  
ойн баяр наадам зохион байгуулах салбар  
хороодыг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус 3 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Их Монгол улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, Зуунмод хот байгуулагдсаны 81 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах салбар хороодыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

1.Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа  
зохион байгуулах салбар хороо:

Дарга:  
М.Отгонбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)  
Дэд дарга:  
Ч.Жавзанпагма (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга)  
С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)  
Ю.Бямбацогт (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

А.Баярын хурал, шагнал, урилга, бэлэг дурсгал,  
баяр наадмын нээлт, хаалт, зохион байгуулалт хариуцсан дэд хороо:

Дарга:  
С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)  
Гишүүд:  
Г.Мөнхгэрэл (Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)  
Д.Оюунсайхан (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны хэлтсийн дарга)  
Б.Оюунцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)  
Д.Баасандорж (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны мэргэжилтэн)  
С.Батзаяа (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны мэргэжилтэн)

4163010873

Х.Гомбосүрэн	(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны мэргэжилтэн)
О.Одончимэг	(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтан)
М.Доржмаа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
5.11.Дархлаажуулалтын арга хэмжээнд автомат тариур хэрэглэхээс зайлсхийх аль болох нэг удаагийн тариур ашиглах, Автомат тариур ашигласан тохиолдолд хий сорогдох, дутуу болон гадуур нь шахагдах зэрэг алдаанаас зайлсхийх, нэг өрхөд ашигласан тариурын зүүг дараагийн өрхөд ашиглахгүй байх, өрх бүрийн малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгах

5.12.Вакциныг малчинд үлдээх, мал, амьтан эмчлэх итгэмжлэлгүй этгээд, улсын байцаагчийн дүгнэлтгүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч, алдаа гаргасан малын эмч нар тарилга хийхийг хориглох, дархлаажуулсны дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэх

5.13.Дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгөх

5.14.Вакциныг хэрэглэх зааварт заасан дархлаа бүрэн дархлаа тогтох хугацаа /21 хоног/ хүртэл тарилгад хамрагдсан өрх нь отор нүүдэл хийхгүй байх анхааруулгыг малчдад өгөх ( МЭЕГ-ын даргын баталсан САЗ-д заасан)

#### ЗУРГАА. ТАЙЛАГНАХ

6.1.Дархлаажуулалсан малыг ялган тэмдэглэх /малчдаар булаг бэлдүүлэх, будуулах, үс, ноосыг хяргах гэх мэтээр/ өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийх, Мал эмнэлгийн нэгдсэн системд мэдээллийг малчны хотноос заавал оруулах, тарилгын явцад бог малын өвчин болон бусад халдварт өвчний шинж тэмдэгийн үзлэг, ажиглалтын арга хэмжээг хэрэгжүүлэх (МЭЕГ-ын даргын баталсан САЗ-д заасан)

6.2.Дархлаажуулалтын ажлыг дүгнэхдээ малын тооны статистек мэдээлэл болон дархлаажуулалтад хамрагдсан малын мэдээллийг тулган нягтлах, зөрүү гарсан тохиолдолд шалтгааныг тодруулж цахим системд тэмдэглэгээ хийх (МЭЕГ-ын даргын баталсан САЗ-д заасан)

6.3.Аймгийн МЭГ-ын мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дархлаажуулалтын өдөр тутмын болон нөхцөл байдлын мэдээллийг тарилга эхэлсэн өдрөөс эхлэн цахимаар илгээсэн хүснэгтийн дагуу өдөр бүрийн 16:30 цагт багтаан цахим хаягаар илгээх

6.4.Отор нүүдлээр яваа малчдад нутаг сэлгэхдээ анхаарах асуудлаар тусгайлсан зөвлөмж өгөх, тухайн өрхийн төлөвлөсөн мэдрэмтгий мал сүргийг бүрэн хамруулах

6.5.Тарилгын цуваа нэг бүрийн дүнг хянаж магадлах, малчдын тамгыг бүрэн даруулсан байх шаардлага тавих

6.6 Дархлаажуулалтын явцад гарсан зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, холбогдох арга хэмжээг хуулийн дагуу авч ажиллах

6.7.МЭҮН-ийн эмч нь тарилгын материалыг тарилга дууссан өдрөөс хойш 15 хоногийн дотор МЭТ ирүүлсэн байх

6.8.Тарилгын гүйцэтгэлд Мал эмнэлгийн улсын байцаагч технологийн хяналт тавьж ажиллах, дархлаажуулалтын ажлын илтгэх хуудас (нэгдсэн тайлан)-ыг цахим хаягаар ирүүлэх зэргээр тайлагнаж ажиллана.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 29 ны өдрийн  
А/365 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ СТАНДАРТ  
АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА (САЗ)  
ТОДОРХОЙЛОЛТ:**

Дархлаажуулалт нь мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэх, эмгэг төрүүлэгчийн дамжин халдварлалтыг бууруулах, эмнэлзүйн шинж тэмдэг үзүүлж өвчлөхөөс хамгаалах, эмгэг төрүүлэгч үржин олширч гадагшлахыг бууруулах үйл ажиллагаа юм.

Яаралтай дархлаажуулалт нь өвчин дэгдэх, гаднаас нэвтрэх эрсдэл нэмэгдэх, дахин сэргэх үеийн яаралтай арга хэмжээнд хэрэглэх дархлаажуулалтыг хэлнэ.

**ЗОРИЛГО**

Бог малын мялзан өвчний эмнэлзүйн шууд нөлөөллийг сүрэг, сум, аймаг, бүс нутгийн түвшинд аль болох үр дүнтэйгээр бууруулах

Эрсдэл бүхий 9 аймаг, нийслэлийн бог малын 2023 оны төл болон ямаа, 4 аймгийн 2023 оны бог малын төлийг хамруулан нэг тунгаар дархлаажуулна.

**ХАМРАХ ХҮРЭЭ**

Бог малын мялзан өвчин гарч хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон өрх, хот айл, ферм, энэ өвчнөөр тайван бус болон халдвар тархах эрсдэлтэй бүс нутагт тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэхүү САЗ-ыг баримтална.

Энэхүү стандарт ажиллагааны зааварчилгаа нь бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамаарна.

Стандарт ажиллагааны зааварчилгааг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч, дайчлагдан ажиллаж байгаа малын их, бага эмч, техникийн ажилтан дагаж мөрдөнө.

**ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Малын их, бага эмч, техникийн ажилтан  
Мэргэжлийн баг

**МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Мал эмнэлгийн эпидемиологич (багийн ахлагч).

Лабораторийн шинжээч

Аймгийн МЭГ, сум, дүүрэг дэх МЭТ, МЭҮН-ийн малын эмч нар

**ШААРДЛАГАТАЙ ЭМ, БЭЛДМЭЛ, БАГАЖ ХЭРЭГСЭЛ**

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин

Зөөврийн хөргүүр, гель

Тариур

Халууны шил

Халдвар хамгааллын хувцасны иж бүрдэл (нэг удаагийн)

Усны гутал  
Хайч, хутга  
Хөвөн  
Зүү баригч  
16С хэмжээтэй зүү  
Маркер - (шилний харандаа)  
Сорьцын сав  
-Сорьцын дагавар хуудас  
Хаягдлын уут  
Халдваргүйтгэгч бодис (6>рН>9 орчинтой)  
Гарариутгагч  
Байршил тогтоогч (СР8 эсвэл гар утсаар авч болно)  
У Зургийн аппарат (гар утсаар баримтжуулж болно)  
Тархварзүйн судалгаа авах маягт  
Хэвлэсэн заавар (бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх,  
тэмцэх)

Дэвтэр, бал  
-Тарилгын акт, жагсаалт

У Мал уяж, бэхлэх олс, дээс, уяа  
Мал цувуулан гүйлгэх хоолой бүхий хашаа  
Вакцин тарихад баримтлах зарчим  
Малчин, амьтан маллагч нь өөрийн болон харьяалан маллаж байгаа зорилтот бог малыг тарилгад бүрэн хамруулах нөхцлийг бүрдүүлсэн байна (МАЭМТХууль 9.8.1, 9.8.2 дах заалт).  
Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"  
МЭЭГ-ын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар"  
МЭЭГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Иордан улсад үйлдвэрлэсэн "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх "Рез^ас" вакциныг хэрэглэх заавар"  
-ХХААХҮСайдын 2010 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан "Мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн заавар"  
МЭЭГ-ын даргын 2018 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл өмсөх, тайлах заавар"-ыг тус тус баримталж ажиллана.  
Тарилга гүйцэтгэхийн өмнө тухайн суурьт бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүхий бог мал байгаа эсэхийг магадлана (эзнээс асуумж авах, сүргийн ерөнхий үзлэг хийх байдлаар).

#### АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Вакцин тарих малын эмч, мал барьж туслах хүн бүр биоаюулгүй байдал, аюулгүй ажиллагааг сайтар бүрдүүлсэн байна. Үүнд: Халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл, мал уяж, бэхлэх уяа, мал цувуулан гүйлгэх хоолой бүхий хашаа зэргийг бүрдүүлж ашиглана.

Тарилгын ажлыг гүйцэтгэх явцад мал хаших хашаа, хороо ашиглан малыг тарих нөхцлийг бүрдүүлнэ. (Энэхүү нөхцлийг малчин бүрдүүлэх бөгөөд багийн Засаг дарга малчинтай холбогдож урьдчилан бэлтгүүлнэ.)

Малын эмч болон туслах ажилтан нь ердийн болон харааны шилийг хамгаалалтын шилний оронд хэрэглэхийг хориглоно. Харааны шилэн дээр хамгаалалтын шилийг давхар зүүж болно. Нүдний шил нь нүдний эргэн тойронд зай завсаргүй нягт сууж, нүүрэнд яг таарсан байна.

Вакцин хүний ам, хамар, чих, нүдэнд орох, санамсаргүй зүүгээр хагахаас сэрэмжилж ажиллана.

Вакцин нүдэнд орох юмуу вакцин тарьж буй зүүгээр биеийн аль нэг хэсэгт хатгавал ажлаа зогсоож эмчид хандана. Нүдэнд вакцин орсон тохиолдолд цэвэр усаар (ус гоожуулж) сайтар угааж, хлорамфеникол эсвэл тетрациклинтэй нүдний дусаалга, тос түрхэнэ.

-Хамгаалалтын 2 давхар бээлий өмсөнө. Урт бээлийг өмсөхдөө халад эсвэл комбинзоны ханцуйг дарж өмсөх хэрэгтэй.

#### САНАМЖ

МЭЭГ болон аймгийн МЭГ-аас баталсан төлөвлөгөө, хуваарийн дагуу дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

У Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарихдаа МЭЭГ-ын даргын баталсан Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх "Резгёуас" вакциныг хэрэглэх зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин нь хуурай вакцин тул тарих зүү, тариур, шингэлэлт хийх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Вакцин тарьсан хэсэгт бохирдол орж, буглаа үүсэхээс сэргийлж өтөг бууцнаас зайдуу сул шороогүй, дагтаршсан хөрстэй талбайд тарилгыг хийвэл зохино.

Бог малын мялзангаас сэргийлэх вакцины тарилгын явцад (+2- +8С°) орчинд байлгаж, шингэлэлт хийсэн вакциныг 2 цагийн дотор хэрэглэнэ.

-Нарны шууд тусгалаас хол, хүүхдийн гар хүрэхгүй газар хадгална.

Хадгалах, тээвэрлэх хүйтэн хэлхээний нөхцлийг хангасан тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар хадгална. Хугацаа нь дууссан вакциныг хэрэглэж болохгүй.

-Цодонг онгойлгосон, шингэлэлт хийсэн вакциныг 2 цагийн дотор хэрэглэж дуусгана.

Шошгогүй, хугацаа дууссан, битүүмжлэл алдагдсан, бохирдсон, өнгө хувирсан, цодонг онгойлгосноос хойш 2 цаг болсон вакциныг хэрэглэхгүй. Вакцинтай хамт хүнсний зүйл хадгалж болохгүй.

Вакцины савыг хүлээн авсан тоо, хэмжээний дагуу МЭҮН тус бүрээр Мал эмнэлгийн тасагт хүлээлгэн өгч, улсын байцаагчийн дүгнэлтийн хамт аймаг, нийслэлийн МЭГ-т хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн МЭГ нь вакцины савыг зааврын дагуу устгаж, улсын байцаагчийн акт үйлдэн, МЭЭГ-ын МЭХБГ-т ирүүлнэ.

#### ЭМ, БИОБЭЛДМЭЛ (ВАКЦИН).

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9-р зүйлийн дагуу төлөвлөж, шаардагдах бэлтгэлийг хангаж зохион байгуулна.

Дархлаажуулалтад идэвхи, аюулгүй чанараараа ДМАЭМБ-ын стандартад нийцсэн, тухайн үед гарч байгаа бог малын мялзангийн вирусын эсрэг дархлаа төрүүлэх өндөр идэвхитэй, сулруулсан, малын эмийн улсын бүртгэлд бүртгэлтэй вакциныг хэрэглэнэ.

Вакцин нь бог малын мялзангийн вирусийн хөлдөөн-хатааж сулруулсан Нигер 75/1 омгийн хамгийн багадаа  $10^{25}$  эс эмгэгшуулэх тун (ЭЭТ) агуулсан бөгөөд тарихын өмнө ариун физиологийн (b1aC1 0.9%) уусмалаар шингэлж хэрэглэнэ.

Гаж нөлөө: Вакцины тунг хэтрүүлэн хэрэглэхэд эмгэгийн шинж тэмдэг илрээгүй. Вакциныг тогтоосон тунгаар хээлтэй, саалийн мал, үржлийн малд хэрэглэхэд аюулгүй. Ховор тохиолдолд тарилга хийх үед жижиг хаван үүсч аажимдаа алга арилна. Нэмэлт эмчилгээ, арчилгаа шаардлагагүй.

#### ВАКЦИН ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ТАРИХ АЖИЛЛАГАА

Вакциныг хадгалах:

Вакциныг сэрүүн (+2°-аас +8°С-т) орчинд харанхуй, хуурай нөхцөлд хадгална.

Вакциныг зориулалтын саванд хадгалж, тээвэрлэнэ.

Вакцин хадгалж байгаа орчны (байр сав, хөргөгч) хэмийг МЭТ байнга хянаж, бүртгэл, тэмдэглэл хөтөлнө.

МЭҮН-д вакцин олгох:

-Бог мал болон төлийг нэг тунгаар тарихаар тооцож, МЭҮН-д олгоно.

МЭҮН-д хуваарьт вакциныг шил бүрээр тоолон олгож, тарилга хийгдэж дууссаны дараа шил тус бүрээр тоолон хүлээж авна.

Вакцин тээвэрлэх

Аймаг, хот, сумдын хооронд алс тээвэрлэх вакциныг зориулалтын хайрцаг (үйлдвэрлэгчийн савлагаатай)-т, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, хөргүүр ашиглан тээвэрлэнэ.

Сум, дүүргийн нутаг дэвсгэрийн дотор, хот айлын хооронд дулаан тусгаарлагч сав (СооНпд Бох, машины хөргүүр) ашиглан зөөвөрлөнө.

Вакцин зөөвөрлөхийн өмнө вакцины хүчинтэй хугацаа, битүүмжлэл, өнгө, хөлдсөн эсэхийг нэг бүрчлэн шалгана.

Вакцин тарих хот айлын малын тоонд хүрэлцэхүйцээр тооцон авч вакцины хүйтэн хэлхээ алдагдуулахаас хамгаалж "сооНпд Бох, хөргүүр"-д хийж, хагарч гэмтэхээс сэргийлэн зөөлөн материалаар сайтар чигжин авч явна.

Вакцин тарихад хэрэглэх тариур, зүү, бусад хэрэгцээт материалыг тусад нь хайрцаглан авч явна.

Вакцин тарихын өмнөх бэлтгэл.

Малын эзнээс тухай суурийн малд бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүхий мал байгаа эсэхийг магадлах, шаардлагатай тохиолдолд асуумж, судалгаа авах, эмнэлзүйн үзлэг хийнэ.

Хүлээн авсан вакциныг савнаас (сооПпд Бох) гаргаж савны бүрэн бүтэн байдал, хадгалах хугацаа, температур, хаяг, шошгоны бүрэн бүтэн байдлыг шалгана.

-Халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бэлдмэлийн нөөцийн бэлэн байдлыг хангана.

Таригдах мал бүрэн байгаа эсэхийг магадлана. (тухайн өрхийн малын А дансны тоотой тулгах)



Вакцин тарих ажиллагаа:

Дархлаажуулалт хийхдээ малчин өрх болон хот айл тус бүрийн хашаанд нь тарих бөгөөд 2 болон түүнээс дээш хот айлын малыг бөөгнүүлж тарихыг хориглоно.

-Вакцин тарих үед зүү, тариурыг хооронд нь сайн угсарч хий сорогдохоос сэргийлнэ.

Малчны хотонд тарилга гүйцэтгэх явцад тарилгын зүүг  $6 > pH > 9$  орчин бүхий халдваргүйжүүлэгч уусмалд (70 хувийн спиртийн уусмал) зүүг ариутгаж, халдваргүйжүүлнэ.

Малыг тарихын өмнө тарих талбай болон тариурын зүүг зориулалтын ариутгагч уусмалаар арчина.

Зорилтот бог малыг толгой дараалан бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинаар нэг тунгаар тарина.

Таригдаж байгаа малын нимгэн арьстай хэсгийн арьсан дор (Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хэрэглэх заавар) тарина.

Эрсдэл бүхий 9 аймаг, нийслэлийн бог малын 2023 оны төл болон ямаа, 4 аймгийн 2023 оны бог малын төлийг хамруулан нэг тунгаар тарина.

Вакциныг малд тарихдаа тарилга хийх хэсгийн арьсыг хуруугаараа чимхэн татаж тариурын зүүг  $45^\circ$  барьж налуу хатган арьсан дор тарина.

Судас болон тунгалагийн зангилаа дайруулж тарьж болохгүй тул анхаарах шаардлагатай.

Тарилгад хамрагдсан малдаа тэмдэглэгээ хийх (будах, ил харагдахуйцаар үс ноосыг хяргах, боломжтой бол ээмэг зүүх гэх мэт)

Баримт бичиг

МЭҮН нь вакцин тарьсны дараа тарилга хийсэн газраас Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэлийн мэдээллийг оруулна.

Тарилга хийснийг нотлох баримтыг бүрдүүлж, тарилгын цуваа, өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл үйлдэж, малчин болон малын эмч гарын үсэг зурж баталгаажуулна.

Тарилгын цуваа, нэгдсэн акт, илтгэх хуудсыг 3-4 хувь үйлдэн тарилга дууссанаас хойш 15 хоногт багтаан МЭТ-т хүлээлгэн өгнө.

Сум, дүүрэг дэх Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч дархлаажуулалтын технологийн болон гүйцэтгэлийн хяналтыг хийж Мал эмнэлгийн нэгдсэн систем дэх гүйцэтгэлтэй тулган хянана.

Тарилга хийсэн ажлын гүйцэтгэлийг хянаж сумын Засаг даргын захирамж, сумын хэмжээнд тарилганд хамрагдсан малчин өрх, малын тоог мал эмнэлгийн нэгж тус бүрээр гаргаж, нэгтгэлийн хүснэгт, нэгдсэн акт, дүгнэлт, нэгжүүдийн тарилгын цуваа, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл зэргийг гаргуулан аймгийн мал эмнэлгийн газарт ажлын 10 хоногт багтаан хүргүүлнэ.

**ТАРИЛГЫН ДАРААХ ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ**

-Тарилга хийж дууссаны дараа хэрэглэсэн хувцас, хэрэгслийг халдваргүйтгэн хог, хаягдлыг зориулалтын цэгт устгана.

Айлаас айл хооронд зорчихдоо биоаюулгүй байдлын дэглэмийг баримталж халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
A/365 05 дугаар сарын 29 ны өдрийн  
дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт



**БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СТАНДАРТ АЖИЛЛАГААНЫ  
ЗААВАРЧИЛГАА /САЗ/ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО:**

Дараах хүчин зүйлүүд нь энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, зорилго болсон. Үүнд:

- 1.1. Хил даван халдварладаг, мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний тохиолдол 2023 оны 05 дугаар сарын байдлаар 5 аймгийн 11 суманд 13 голомт бүртгэгдсэн;
- 1.2. Улсын хэмжээнд 2021-2022 онд бог малын мялзангаар өвчилсөн малын 60 орчим хувийг төл болон ямаа эзэлж байгаа;
- 1.3. Өвчний гаралт, тархалт 2022-2023 онд төв болон зүүн бүсийн аймгуудад тархаад байгаа;
- 1.4. Бог малын мялзангаар өвчилсөн мал мэдрэмтгий сүрэг дотор 2,2 толгой малд халдвар тархаах эрсдэлтэй;
- 1.5. Бог малын мялзан өвчинд мэдрэмтгий бүх бог малыг (60 сая) хамруулах вакцины хүрэлцээ хангалтгүй байдал;
- 1.6. Дээрх нөхцөл байдлыг харгалзан төв, зүүн бүсийн 9 аймаг, нийслэлийн бог малын 2023 оны төл болон ямаа, 4 аймгийн 2023 оны бог малын төлийг хамруулан дархлаажуулалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

Хүн хүчний нөөц:

Мал эмнэлгийн ерөнхий газар

- Улсын хэмжээнд тарилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүн хүчний нөөцийн судалгааг гаргах, нэмэлт хүн хүчийг дайчлах боломжийг бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, холбогдох шийдвэр гаргуулах

Аймаг, нийслэлийн МЭГ

- Аймаг, нийслэлийн хэмжээнд тарилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүн хүчний нөөцийн судалгааг гаргах, нэмэлт хүн хүчийг дайчлах боломжийг бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, холбогдох шийдвэр гаргуулах

Мал эмнэлгийн тасаг

- Сумын хэмжээнд тарилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хүн хүчний нөөцийн судалгааг гаргах, нэмэлт хүн хүчийг дайчлах боломжийг бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, холбогдох шийдвэр гаргуулах

Хамтран ажиллах байгууллага, иргэд:

- МЭЕГ, АНМЭГ, МЭТ-аас дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын талаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ болон мэргэжлийн ангийг арга зүйгээр хангах,

- Аймаг, сумын Засаг дарга нь дархлаажуулалтын ажил зохион байгуулах Захирамжийг баталгаажуулан, УИХ-ын түр хорооны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу МЭҮН-д шатахууны дэмжлэг үзүүлэх,

- МЭЕГ, АНМЭГ, МЭТ-аас өгсөн мэдээллийн дагуу малчин нь малын хашаа, мал бэхлэх хэрэгсэл, малаа тарилгад бүрэн хамруулах зэрэг бэлэн байдлыг хангах.

Харилцаа, холбоо мэдээ дамжуулалт:

- МЭТ-ийн тархварзүйч нь МЭНС-д төлөвлөлтийг оруулан мал эмнэлгийн улсын байцаагч баталгаажуулах,

- МЭҮН-ийн эмч нь тарилгад гарахын өмнө багийн Засаг даргаар дамжуулан эсвэл өөрөө утсаар холбогдож малчинд тарилга хийх хугацаа, товыг урьдчилан хүргүүлэх,

- Тарилга хийгдсэн малчин бүрийн хотноос тарилгын гүйцэтгэлийг МЭНС-д оруулах.

- МЭҮН-ийн эмч тарилгын гүйцэтгэлийг өдөр бүр МЭТ-ийн тархварзүйчид утсаар мэдээлэх,

- Тарилга гүйцэтгэх явцад бог малын мялзан болон бусад халдварт, гоц халдварт өвчний шинж тэмдэг бүхий мал, амьтан илэрсэн тохиолдолд МЭТ-д яаралтай мэдэгдэж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.

- МЭТ-ийн тархварзүйч нь дархлаажуулалтын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн тухайн өдрийн 15 цагаас өмнө АНМЭГ-т хүргүүлэх,

- АНМЭГ-ын өвчний мэдээ, тайлан, цахим бүртгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нь МЭТ-аас 14:00 цагт дархлаажуулалтын мэдээг ирүүлэх

Багаж, хэрэгслийг халдваргүйтгэх:

- Гүйцэтгэхдээ антисептик, асептикийн дүрмийг сайтар баримтална,
- Нэг малчны хотонд ашигласан зүүг халдваргүйтгэхгүйгээр дараагийн малчны хотонд ашиглахгүй,

- Малчны хотонд тарилга гүйцэтгэх явцад тарилгын зүүг  $6 > pH > 9$  орчин бүхий халдваргүйжүүлэгч уусмалд (70 хувийн спиртийн уусмал) тарилгын зүү, тариурыг халдваргүйтгэх,

- Нэг малчны хотноос нөгөө малчны хотонд шилжихдээ тариур, зүү, бусад багаж, хэрэгслийг  $6 > pH > 9$  орчин бүхий халдваргүйтгэлийн уусмал (70 хувийн спиртийн уусмал)-аар халдваргүйтгэх.

- Халдвар хамгааллын хувцасыг (нэг удаагийн) устгах, халдваргүйтгэх (олон удаагийн хувцас) арга хэмжээг хэрэгжүүлэх.

- Тээврийн хэрэгслийн дугуй, машины доод талбайн хэсэг, гутлын ул зэргийг халдваргүйтгэх.

Малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах:

- Дархлаажуулалтад хамрагдсан мал, амьтанд дархлаа бүрэн тогтох хүртэл 21 хоногт малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх

- Тарилгад хамрагдсаны дараа бог малын мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэж, хүн малын шилжилт хөдөлгөөнийг хориглох

Малчинд өгөх зөвлөмж:

- Дархлаажуулалтын зорилго, хугацаа, хамрагдах малын талаарх мэдээлэл хүргэх
  - Тарилгад хамруулах өрх нь малын хашаа, мал бэхлэх хэрэгсэл, мал барих хүн хүч, тарилгад хамруулах малаа товлосон хугацаанд бүрэн бэлэн байлгах, бүрэн хамруулахыг урьдчилан мэдэгдэх
    - Мал, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах
    - Малчинд тарилга хийснээс хойш 21 хоногийн хугацаанд шаардлагагүй бол хүний хөдөлгөөн хийхгүй байх, малаа бусад айлын малтай нийлүүлэхгүй, байнгын хариулга маллагаатай байлгах талаар зөвлөх
    - Бог малын мялзан өвчний гаралт, тархалтын нөхцөл байдал намжтал отор нүүдлийн зорилгоор аймаг дамжсан малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байхыг анхааруулах
      - Малын арчилгаа, маллагаа, тэжээллэгийн нөхцлийг сайжруулах
      - Тарилга хийсний дараа бог малын мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах мал эмнэлэгтээ яаралтай мэдэгдэхийг анхааруулах
      - Тарилгад хамрагдсан малдаа тэмдэглэгээ хийх (будах, ил харагдахуйцаар үс ноосыг хяргах, боломжтой бол эзэмэг зүүх гэх мэт)-ийг анхааруулах

Олон нийтэд мэдээлэл хүргэх:

- Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ
  - Хорио цээрийн арга хэмжээ
  - Халдваргүйтгэлийн арга хэмжээ
  - Дархлаажуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх ажлын талаар тодорхой мэдээллийг хүргэх
    - [bhp8://yuyuyu.yoi1ibe.cot/yua1cb?y=дУУк1ү8ь 15с~](http://bhp8://yuyuyu.yoi1ibe.cot/yua1cb?y=дУУк1ү8ь 15с~) ;
    - [bhp5://yululll/.yoi\(ibe.cot/yua1cb?y=|дуиьМсүК-уу](http://bhp5://yululll/.yoi(ibe.cot/yua1cb?y=|дуиьМсүК-уу)
    - [bhp1://lullull/.yoi1ibe.cot/l/a1cb?y=9\(K1yЦK49CA](http://bhp1://lullull/.yoi1ibe.cot/l/a1cb?y=9(K1yЦK49CA) - бог малын мялзан
    - [bhp8://lullulllyoi1ibe.cot/yua1cb?y=TP2:o2Ya2M7c](http://bhp8://lullulllyoi1ibe.cot/yua1cb?y=TP2:o2Ya2M7c)
    - [bhp8://lullulllyoi\(ibe.cot/l/a1cb?y=X1oMO OHEЦA](http://bhp8://lullulllyoi(ibe.cot/l/a1cb?y=X1oMO OHEЦA)
    - [bhp8://yululll/.yoi<ibe.cot/l/a1cb?y=CK9oOT 1 Kyak - YATӨ](http://bhp8://yululll/.yoi<ibe.cot/l/a1cb?y=CK9oOT 1 Kyak - YATӨ)
    - [bhp8://lullulll/yoi1ibe.cot/l/a\(cb?y=EipY2E|ac1OA](http://bhp8://lullulll/yoi1ibe.cot/l/a(cb?y=EipY2E|ac1OA) - хонь, ямааны цэцэг
    - Малчид, иргэдэд цахим болон цаасан хэлбэрээр гарын авлага материалыг хүргүүлэх

### ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ:

#### Тарилга гүйцэтгэх газрын зураглалыг гаргах:

- МЭЕГ нь улсын хэмжээнд дархлаажуулалт зохион байгуулах зураглал, тооцоог гаргах
  - АНМЭГ нь өөрийн аймгийн хэмжээнд дархлаажуулалт хийх газрын зураглал, тарилга гүйцэтгэх төлөвлөгөөг нарийвчлан гаргах
  - АНМЭГ-аас өгсөн мэргэжил, аргазүйн дагуу МЭТ, МЭҮН нь сум, дүүргийн ЗДТГ болон багийн Засаг даргатай хамтран тухайн сумын хэмжээнд дархлаажуулалт зохион байгуулах газрын зураглал /малчин өрхийн байршил, өрхийн эзний нэр, утасны дугаар, малын тоо төрлөөр, айл хоорондын км-ийг багтаасан байна/, тарилга гүйцэтгэх төлөвлөгөөг нарийвчлан гаргах

#### Тарилга гүйцэтгэх маршрут чиглэлийг гаргах:

- МЭЕГ нь улсын хэмжээнд хэрэгжүүлэх дархлаажуулалтын чиглэл маршрутыг гаргаж, АНМЭГ, МЭТ, МЭҮН-ийг мэргэжлийн удирдлага, аргазүйгээр хангана.
  - АНМЭГ нь тухайн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх дархлаажуулалтын чиглэл маршрутыг гаргаж, МЭТ, МЭҮН-ийг мэргэжлийн удирдлага, аргазүйгээр хангах,
  - МЭТ нь тухайн сумын хэмжээнд хэрэгжүүлэх дархлаажуулалтын чиглэл маршрутыг гаргаж, МЭҮН, тарилга гүйцэтгэх малын эмчийг мэргэжлийн удирдлага, аргазүйгээр хангана.
  - Аймаг, нийслэлийн түвшинд тарилга гүйцэтгэх чиглэл, маршрутыг гаргахдаа эрсдэл багатай сум, хилийн боомт, олон улсын болон улсын чанартай авто зам дагуух бүс нутгийг эхлэн хамруулах, өвчний хорио цээр хэрэгжиж байгаа сумыг чиглэсэн байдлаар зохион байгуулна.
  - Сум, дүүргийн түвшинд тарилга гүйцэтгэх чиглэл, маршрутыг гаргахдаа өвчлөлгүй, эрүүл хэсгээс өвчний хорио цээр хэрэгжиж байгаа голомт, эрсдэл бүхий зэргэлдээ сумыг чиглэсэн байдлаар зохион байгуулна.
  - Тарилга гүйцэтгэх эмч нь МЭТ-аас гаргасан зураглал, маршрут, чиглэлийн дагуу тарилгын ажлыг гүйцэтгэнэ.

#### Вакцин хадгалах, тээвэрлэх:

##### Мал эмнэлгийн ерөнхий газар:

- Вакцины хүйтэн хэлхээний технологийн горимыг хангаж, зориулалтын хөргүүртэй агуулахад хадгална. /+2-+8/;
- МЭЕГ-ын даргын баталсан хуваарийн дагуу холбогдох аймгийн МЭГ-т зориулалтын тээврийн хэрэгслээр хүйтэн хэлхээний технологийн горимын нөхцлийг хангуулж /+2-+8/ хяналт тавин хүргэж, хүлээлгэн өгнө.

##### Аймаг, нийслэлийн МЭГ:

- МЭЕГ-аас баталсан хуваарийн дагуу вакциныг хүлээн авч /АМЭГ хяналт тавьж, нярав хариуцан/ зориулалтын агуулахад хадгална /+2-+8/;
- МЭЕГ-ын даргын баталсан хуваарь, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, МЭГ-ын даргын баталсан хуваарийн дагуу сумдад вакциныг хуваарилан нярав хариуцан олгоно. /аймгийн МЭГ-ын МЭУБ хяналт тавих/
  - Хуваарьт вакциныг шил бүрээр тоолон олгож, тарилга хийгдэж дууссаны дараа шил тус бүрээр тоолон хүлээж авахаар тооцож, бүртгэл хийж МЭТ-т олгоно.
  - Аймгийн МЭГ болон МЭТ нь зориулалтын хөргүүр бүхий тээврийн хэрэгсэл /+2-+8/ эсвэл машины хөргөгч ашиглан тээвэрлэж суманд хүргэнэ.

Сум, дүүргийн МЭТ:

- Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, АНМЭГ-ын даргын баталсан хуваарийн дагуу тэмдэглэгээ хийгдсэн вакциныг МЭТ хүлээн авч хөргүүр бүхий агуулах эсвэл бага оврын хөргүүрт /+2-+8/ хадгална. /МЭУБ хяналт тавина./

- МЭҮН-д хуваарьт вакциныг шил бүрээр тоолон олгож, тарилга хийгдэж дууссаны дараа шил тус бүрээр тоолон хүлээж авахаар тооцож вакциныг батлагдсан хуваарь, сум, дүүргийн Засаг даргын захирамж, МЭТ-аас гаргасан зураглалын дагуу МЭҮН-д вакциныг бүртгэл хөтлөн хуваарилан олгоно. /МЭУБ хяналт тавина./

МЭҮН-ийн болон тарилга гүйцэтгэж байгаа эмч:

- МЭТ-аас хуваарилан олгосон вакциныг зориулалтын хөргүүр бүхий машин эсвэл бага оврын хөргүүр ашиглан /+2-+8 хэмд/ сумаас хот айл болон айл хооронд тээвэрлэж, хадгална.

Тарилга гүйцэтгэх МЭҮН-ийн эмч дархлаажуулалт хийхэд баримтлах САЗ-ыг мөрдөн тарилгын ажлыг гүйцэтгэнэ.

**ВАКЦИНЫ ДАРХЛАА, ХЯНАЛТ МОНИТОРИНГ:**

Дархлаа тогтох, үргэлжлэх хугацаа:

- Монгол улсад 2021 оноос хойш гарч байгаа бог малын мялзан өвчин нь IV удмын генээр үүсгэгдсэн болохыг Английн Пирбрайттын хүрээлэнгийн хариугаар генийн дарааллын хувьд Монгол, БНХАУ-д 2014-2017 онд оношлогдсон үүсгэгчтэй ойролцоо болохыг тогтоосон.

- Иордан улсад үйлдвэрлэсэн бог малын мялзангийн вирусийн Нигери 75/1 омгоор үйлдвэрлэсэн сулруулсан амьд вакцин нь бог малын мялзан өвчний үүсгэгчийн IV удмын генээр үүсгэгдсэн өвчнөөс хамгаалах бүрэн боломжтой бөгөөд зааврын дагуу тарьснаас хойш 36 сар дархлаа тогтоно.

- Вакциныг хэрэглэх зааварт заасны дагуу тарьсан тохиолдолд дархлааны үргэлжлэх хугацаа 36 сар байна.

Вакцин тарьсны дараа халдвар авах эрсдэл:

- Вакцин таригдсанаас хойш бүрэн дархлаа тогтох 21 хоногийн дотор бог малын мялзан өвчний халдвар авсан тохиолдолд ил шинж тэмдэг илрэх эрсдэлтэй.

- Бог малын мялзан өвчний халдвар аваад удаагүй /7-10 хоног/ болон халдвар аваад шинж тэмдэг илрэх хүртэлх нууц үедээ байгаа малд вакцин тарьсан тохиолдолд 3-5 хоногт уг өвчний шинж тэмдэг сул байдлаар илэрнэ.

Тарилгын гүйцэтгэлд хяналт, мониторинг хийх:

- МЭТ-ийн МЭУБ нь дархлаажуулалтын явцын болон гүйцэтгэлийн хяналтыг хийж, МЭНС-ийн мэдээтэй тулган, баталгаажуулна.

АНМЭГ-ын МЭУБ нь өдөр тутам МЭТ-аас ирүүлж байгаа мэдээг МЭНС-ээр хянаж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь тарилгын гүйцэтгэлд хяналт тавина.

МЭЕГ-аас тарилгын явцыг МЭНС-ээр дамжуулан хянаж, гүйцэтгэл, баталгаажуулалтыг хангуулна.

Орон нутагт ажиллаж байх үед шаардлагатай тохиолдолд газар дээр нь зохих заавар, технологийн дагуу тарилгыг гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавина.

МЭЕГ-аас дархлаажуулалтын үр дүнг үнэлэх зорилгоор ийлдсийн сорьц авч, УМЭАЦТЛ-ийн шинжилгээгээр дархлааны идэвхийг тогтоож, үр дүнг үнэлнэ.

**ХЯНАСАН:**

МАЭМГ-ын даргын албан  
үүргийг түр орлон  
гүйцэтгэгч



Т.Тунгалаг

ТЗМССГ-ын даргын  
албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч



С.Батхуяг

**БОЛОВСРУУЛСАН:**  
Ахлах мэргэжилтэн

Х.Бодьсайхан



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/371

Зуунмод

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн  
хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 279 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 ээлжит бус 5 дугаар хуралдааны оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаалгах иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаалгах иргэдийн хугацааг 2023 оны 06 дугаар сарын 08-наас эхлэн 2025 оны 06 дугаар сарын 08-аар дуусгавар болгохоор тооцсугай.

3.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа алба хаагчдын сургалт, цугларалт, дайчилгаа өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулж явуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх хааж байгаа алба хаагчидтай жилд 2 удаа 10 хоногийн сургалт, алба хаах хугацаанд нь 6 сараас доошгүй дүйцүүлэх албаны оногдуулсан үүргийг биечлэн гүйцэтгүүлж, тайлан мэдээг улирал бүр Цэргийн штабт өгч байхыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт даалгасугай.

5.Зарлан дуудах хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй, төлөвлөгөөт сургалтыг удаа дараа тасалсан, оногдуулсан үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн болон алба хаагч иргэнийг цэргийн дүйцүүлэх албанаас хасч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхийг Цэргийн штабын дарга (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123010958

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa



Аймгийн Засаг даргын 2023 оны  
 05 дугаар сарын 31 -ны өдрийн  
 А/З/А дугаар захирамжийн хавсралт



2023-2025 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН  
 ХААХ ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Сумын нэр	Овог нэр	Регистрийн дугаар	Тайлбар
1	Аргалант	Энхбаатар Төгөлдөр	НЬ04272811	
2		Хүрлээ Алтанбагна	ДВ040425281	
3		Даваасүрэн Дашням	НК00292415	
4		Энхтуяа Баасансүрэн	УП03312639	
5		Баатархорол Төрсайхан	УП00321158	
6		Лувсан Аранжин	НИ02282814	
7		Отгонбаяр Мөнгөнсүх	ГО02320516	
8		Ганболд Баянмөнх	ПМ02222017	
9		Ганзориг Түвшинбат	ВЕ01301017	
10		Цэгмид Эрдэнэ-Очир	НЬ03242219	
11	Батсүмбэр	Батнасан Болор-Эрдэнэ	НУ03252411	
12		Лхагвасүрэн Ёндонжамц	НБ04281919	
13		Сэрбаатар Дөлгөөнтамир	НБ04220615	
14		Цогбадрах Гантулга	НБ03291813	
15		Баянмөнх Батболд	НБ03240517	
16		Гантогтох Барсболд	НБ01281815	
17		Булган Ган-Эрдэнэ	УО03251299	
18	Баянжаргалан	Төмөххуяг Батзориг	НӨ03290216	
19		Цэрэндолгор Очирдарь	НӨ03211313	
20		Батжаргал Сайнбат	НӨ04272310	
21		Базаррагчаа Эрдэнэбат	НӨ04302618	
22		Даваамандах Отгонбаяр	НӨ02210115	
23		Шагдар Өнөрбат	НӨ03211712	
24	Бүрэн	Батцэнгэл Бат-Эрдэнэ	НК01231419	
25		Товуу Бат-Оргил	НК02291612	
26		Бат-Очир Билгүүн	НК03271311	
27		Бархасболд Ёндонжамц	НК03290438	
28		Мөнхбат Мэндбилэг	НК00251411	
29		Баярсайхан Санчир	НК02242711	
30		Цэндсүрэн Лхагвадорж	НК01300318	
31		Дармаабуд Цогтсайхан	НК00272119	
32		Эрдэнэбилэг Амарсайхан	НК00232093	
33		Шинэхүү Сүхтөмөр	НК02270911	
34		Гэрэлмаа Гончигням	НК01231818	
35	Лүн	Энхбаяр Түвшинбаяр	НО04292519	
36		Эрдэнэбат Содном-Очир	НО03210519	
37		Ганбаатар Уртнасан	НО03240812	
38		Ганбат Содном	ОО02221111	
39		Равжир Жанбал	НО01252416	
40		Цогтгэрэл Энх-Амгалан	УК04213034	
41		Энхбатын Онон	НА04262315	
42	Зуумод сум 1-р баг	Чинбатын Нямбаатар	НЭ02211314	
43		Лувсанжамцын Пүрэвням	НЭ02211012	

44	Зуунмод сум 2-р баг	Болдбаатарын Өнөболд	НЭ02322014	
45		Отгбиш Мягмарнаран	УИ00241119	
46	Зуунмод сум 3-р баг	Гомбын Чимэд-Очир	НЭ00322133	
47		Сүрхийсайхан Энхтөгөлдөр	НЭ99030813	
48	Зуунмод сум 4-р баг	Батбаатар Ууганбаатар	НК04312415	
49		Батбаяр Сонинбаяр	УХ04282792	
50	Зуунмод сум 5-р баг	Түвшинтөгс Агваантүвшин	НЭ05277303	
51		Ганхөлегийн Тэмүүжин	НЭ02211217	
52	Зуунмод 6-р баг	Очирсүх Болдсүх	НЭ00280413	
53		Мөнхдэлгэр Дамдинсүрэн	НЭ01260511	
54	Эрдэнэсант	Насандэлгэр Дашпүрэв	НФ04280513	
55		Ганхуяг Хүдэрбаяр	НФ02252215	
56		Төгөлдөр Эрхтөгөлдөр	НФ00220811	
57		Тэрбиш Бат-Эрдэнэ	НФ04240816	
58		Оюунаа Батдөлгөөн	НФ02241716	
59		Дашдаваа Болдбаатар	НФ01221211	
60		Готовдорж Шижирбаатар	НФ01212113	

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/372

Зуунмод

Цугларалт зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Дүйцүүлэх албаны журмын 1.6, 3.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 279 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 215 дугаар тогтоолын "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөгчдийн хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус 5 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн сургалтыг Зуунмод сумын төвд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.

2.Цугларалтад оролцох бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт, дадлагыг тусгай хөтөлбөрийн дагуу чанартай, сахилга зохион байгуулалт сайтай явуулж ажиллахыг Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-т даалгасугай.

4.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа алба хаагчдыг үүргийн дагуу орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд оролцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Цугларалтын хугацаанд бие бүрэлдэхүүнд мэргэжлийн хичээл сургууль орох офицер, ахлагч болон бусад шаардлагатай зүйлээр дэмжлэг тусалцаа үзүүлж хамтран ажиллахыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч (Хурандаа Ж.Мөнхбаяр), Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

5.Цугларалтад хамрагдах Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн ирж, очих тээвэрлэх авто техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулж, шаардагдах шатахуун тосолгооны материалаар хангах, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4123010960

My doc:zahiramj2023-2 uliral. s/maa

6.Цугларалтад шаардагдах зардал болох 17,233,250 (арван долоон сая хоёр зуун гучин гурван мянга хоёр зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны  
 А/372 05 дугаар сарын 31 ны өдрийн  
 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



2023-2025 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН  
 ХААХ ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Сумын нэр	Овог нэр	Регистерийн дугаар	Тайлбар
1	Аргалант	Энхбаатар Төгөлдөр	НЬ04272811	
2		Хүрлээ Алтанбагна	ДВ040425281	
3		Даваасүрэн Дашням	НК00292415	
4		Энхтуяа Баасансүрэн	УП03312639	
5		Баатархорол Төрсайхан	УП00321158	
6		Лувсан Аранжин	НИ02282814	
7		Отгонбаяр Мөнгөнсүх	ГО02320516	
8		Ганболд Баянмөнх	ПМ02222017	
9		Ганзориг Түвшинбат	ВЕ01301017	
10		Цэгмид Эрдэнэ-Очир	НЬ03242219	
11	Батсүмбэр	Батнасан Болор-Эрдэнэ	НУ03252411	
12		Лхагвасүрэн Ёндонжамц	НБ04281919	
13		Сэрбаатар Дөлгөөнтамир	НБ04220615	
14		Цогбадрах Гантулга	НБ03291813	
15		Баянмөнх Батболд	НБ03240517	
16		Гантогтох Барсболд	НБ01281815	
17		Булган Ган-Эрдэнэ	УО03251299	
18	Баянжаргалан	Төмөххуяг Батзориг	НӨ03290216	
19		Цэрэндолгор Очирдарь	НӨ03211313	
20		Батжаргал Сайнбат	НӨ04272310	
21		Базаррагчаа Эрдэнэбат	НӨ04302618	
22		Даваамандах Отгонбаяр	НӨ02210115	
23		Шагдар Өнөрбат	НӨ03211712	
24	Бүрэн	Батцэнгэл Бат-Эрдэнэ	НК01231419	
25		Товуу Бат-Оргил	НК02291612	
26		Бат-Очир Билгүүн	НК03271311	
27		Бархасболд Ёндонжамц	НК03290438	
28		Мөнхбат Мэндбилэг	НК00251411	
29		Баярсайхан Санчир	НК02242711	
30		Цэндсүрэн Лхагвадорж	НК01300318	
31		Дармаабүд Цогтсайхан	НК00272119	
32		Эрдэнэбилэг Амарсайхан	НК00232093	
33		Шинэхүү Сүхтөмөр	НК02270911	
34		Гэрэлмаа Гончигням	НК01231818	
35	Лүн	Энхбаяр Түвшинбаяр	НО04292519	
36		Эрдэнэбат Содном-Очир	НО03210519	
37		Ганбаатар Уртнасан	НО03240812	
38		Ганбат Содном	ОО02221111	
39		Равжир Жанбал	НО01252416	
40		Цогтгэрэл Энх-Амгалан	УК04213034	
41	Зуумод сум 1-р баг	Энхбатын Онон	НА04262315	
42		Чинбатын Нямбаатар	НЭ02211314	
43		Лувсанжамцын Пүрэвням	НЭ02211012	

44	Зуунмод сум 2-р баг	Болдбаатарын Өнөболд	НЭ02322014	
45		Отгбиш Мягмарнаран	УИ00241119	
46	Зуунмод сум 3-р баг	Гомбын Чимэд-Очир	НЭ00322133	
47		Сүрхийсайхан Энхтөгөлдөр	НЭ99030813	
48	Зуунмод сум 4-р баг	Батбаатар Ууганбаатар	НК04312415	
49		Батбаяр Сонинбаяр	УХ04282792	
50	Зуунмод сум 5-р баг	Түвшинтөгс Агваантүвшин	НЭ05277303	
51		Ганхөлөгийн Тэмүүжин	НЭ02211217	
52	Зуунмод 6-р баг	Очирсүх Болдсүх	НЭ00280413	
53		Мөнхдэлгэр Дамдинсүрэн	НЭ01260511	
54	Эрдэнэсант	Насандэлгэр Дашпүрэв	НФ04280513	
55		Ганхуяг Хүдэрбаяр	НФ02252215	
56		Төгөлдөр Эрхтөгөлдөр	НФ00220811	
57		Тэрбиш Бат-Эрдэнэ	НФ04240816	
58		Оюунаа Батдөлгөөн	НФ02241716	
59		Дашдаваа Болдбаатар	НФ01221211	
60		Готовдорж Шижирбаатар	Нф01212113	

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 31 -ны өдрийн  
А/372 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭХ ХААХ АЛБА  
ХААГЧТАЙ ХИЙХ СУРГАЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр төрөл	Хоног	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хоолны зардал	10	60 хүн	18,000	10,800,000
2	Дүйцүүлэх хувцас	10	60	90,000	5,400,000
3	Түлшний мод	10	3М3	180,000	540,000
4	Хэрэглээний цэвэр ус	10	5 тн	1т	50,000
5	Шатахуун /Цэрэг тээвэрлэх, тохижилтын ажил хийх/	10	50км х 5х=250км 250км х0,45=90л	3940	443,250
	Нийт				17,233,250

ХЯНАСАН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАВЫН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА Т.ТӨМӨРЧӨДӨР